

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг хууль, журамд
заасан арга хэмжээнд зарцуулаагүй байна.

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬ, ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ”-Д
ХИЙСЭН НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ДОА-2021/80-ШТА-НА

Чойбалсан хот 2021 он



Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Б.Болортуул
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер И.Сэмжидмаа
Утас: 7058-4204, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn
Ахлах аудитор Б.Батжаргал
Утас: 7058-4207, Цахим хаяг: batjargalb@audit.gov.mn
Аудитор М.Ухаанбилэг
Утас: 7058-4207, Цахим хаяг: ukhaanbilegm@audit.gov.mn
Гэрээт аудитор З.Шинэхүү
Утас: 7058-4207, Цахим хаяг: shinekhuuz@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

Товчилсон үгийн тайлбар.....	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	4
1. АЙМГИЙН ИТХ, ЗАСАГ ДАРГА БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ЗААСАН БҮРЭН ЭРХЭЭ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ХАНГАЛТГҮЙ БАЙНА.	
1.1 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг төлөвлөхдөө хууль, журамд заасны дагуу менежментийн төлөвлөгөө, мэдээллийн санд үндэслэн боловсруулаагүй байна.....	5
1.2 Аймгийн ИТХ нь байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээний биелэлтэд хяналт тавьж ажиллаагүй байна.....	5
1.3 Аймгийн Засаг дарга байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлаар санхүүжих төсөл арга хэмжээг бодитой төлөвлөөгүй байна.....	6
2. БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ОРЛОГЫГ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ДАГУУ ТӨВЛӨРҮҮЛСЭН БАЙНА.	
2.1. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг бодитой төлөвлөсөн байна.....	7
2.2 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө биелсэн байна.....	7-8
3. БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ОРЛОГЫГ ХУУЛЬ, ЖУРАМД ЗААСАН АРГА ХЭМЖЭЭНД ЗАРЦУУЛААГҮЙ БАЙНА.	
3.1 Ус ашигласны төлбөрийн орлогоос усны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээхэд хуульд заасан хувь, хэмжээнээс бага хөрөнгө төлөвлөсөн байна.....	9
3.2 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг хууль, журамд заасан арга хэмжээнд зарцуулаагүй байна.....	9-10
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:.....	11
ДҮГНЭЛТ:.....	12
ЗӨВЛӨМЖ:.....	12
ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ:.....	13-14
АЛБАН ШААРДЛАГА:.....	15-17

Товчилсон үгийн тайлбар

НА	Нийцлийн аудит
ТАБ	Төрийн аудитын байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
БОАЖС	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
MNS	Монгол Улсын Стандарт
ШТА	Шууд тайлагнах аудит

	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/28 тоот тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын 2021 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөөний дагуу гүйцэтгэсэн.
Аудитын зорилт	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтэд аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, аудитын дүнг, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн. Дээрх зорилтын хүрээнд дараах дэд зорилтын дагуу аудитыг гүйцэтгэсэн. Үүнд: • Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон аймаг, сумын ИТХ, Засаг дарга нь байгаль орчныг хамгаалах талаар хуульд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлсэн эсэх; • Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу төлөвлөж бүрэн төвлөрүүлсэн эсэх; • Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд хуваарилсан хөрөнгийн зарцуулалт хууль тогтоомжтой нийцсэн эсэх;
Аудитын хамарсан хүрээ	Тус аудитад аймаг, сумын ИТХ, Засаг дарга, ЗДТГ, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Татварын хэлтэс, Мэргэжлийн хяналтын газар, Онон-Улз голын сав газрын захиргаа, сумдын байгаль орчны байцаагч, байгаль хамгаалагч, холбогдох байгууллага, аж ахуй нэгжүүдийн 2020 оны үйл ажиллагааг хамруулан тэдгээрийн ажлын тайлан, статистик мэдээ, баримт материалыг түүвэрлэн шалгасан.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхэд Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит, Тулгуур зарчим”, MNS 6817-6:2020 “Төрийн аудит, Нийцлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит, Нийцлийн аудит” стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан ТАБ-аас аудит хийх журам, МУЕА-ын 2021 оны А/71 дүгээр тушаалаар баталсан “Нийцлийн аудитын заавар, аргачлал”-д заасны дагуу холбогдох албан тушаалтнуудтай уулзалт, ярилцлага зохион байгуулах, судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашигласан.
Үндсэн мэдээлэл	Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь БОАЖ-ын сайд, аймгийн Засаг даргатай байгаль орчин, аялал жуулчлалын бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх тухай 2020 онд байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээнд байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 48 төсөл арга хэмжээ, үйлчилгээг төлөвлөн 98 хувийн биелэлттэй дүгнүүлсэн байна. /Эх сурвалж: аймгийн БОАЖГ-ын 2020 оны үйл ажиллагааны тайлан/
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Болортуул удирдаж, үе шатны болон чанарын хяналтыг аудитын менежер И.Сэмжидмаа хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Батжаргал, аудитор М.Ухаанбилэг, гэрээт аудитор З.Шинэхүү нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэсэн.

БҮЛЭГ 1. АЙМГИЙН ИТХ, ЗАСАГ ДАРГА БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ЗААСАН БҮРЭН ЭРХЭЭ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

1.1 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг төлөвлөхдөө хууль, журамд заасны дагуу менежментийн төлөвлөгөө, мэдээллийн санд үндэслэн боловсруулаагүй байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын газраас 2020 онд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхэд 35 арга хэмжээнд 1,200.0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж аймгийн хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст санал хүргүүлсэн байна.

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг ургамал, ой, усны нөөцийн, агнуурын, тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөө, байгалийн баялгийн нөөцийн үнэлгээнд үндэслэж төлөвлөсөн эсэхийг үзэхэд дараах байдалтай байна.

Баян-Уул сумын Ойн менежментийн төлөвлөгөөг 2020 онд боловсруулан аймгийн Засаг даргаар батлуулан ажилласан байна.

Аймгийн хэмжээнд усны нөөцийн болон ан агнуурын менежментийн төлөвлөгөө байхгүй. Ургамал хамгааллын менежментийн төлөвлөгөөг 2018 онд боловсруулан батлуулсан ч төлөвлөгөөний дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээ байхгүй байна. Энэ нь Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 2.2¹-т заасантай нийцэхгүй байна. Иймд аймгийн засаг даргад хууль, журмыг мөрдөж ажиллах зөвлөмж өгөв.

Усны тоо бүртгэлийг аймаг, сумын хэмжээнд зохион байгуулж мэдээллийн санд оруулсан эсэхийг шалгахад 2015 оноос хойш усны тоо бүртгэлийг хийгээгүй мэдээллийн санг хөтлөөгүй байна. Энэ нь Усны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3. “Усны тоо бүртгэлийг аймаг, сум, дүүргийн хэмжээнд тухайн шатны Засаг дарга жил бүр зохион байгуулж, улсын усны мэдээллийн санд оруулна.” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна. Иймд аймгийн Засаг даргад усны тоо бүртгэлийг зохион байгуулж, мэдээллийн санд оруулж ажиллах зөвлөмж өгөв.

Аймгийн хэмжээнд тухай жилд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг төлөвлөхдөө хууль, журамд заасны дагуу менежментийн төлөвлөгөө, мэдээллийн санд үндэслэн боловсруулаагүй байна.

1.2 Аймгийн ИТХ нь байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээний биелэлтэд хяналт тавьж ажиллаагүй байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 09 дүгээр тогтоолоор Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлаар 2020 онд шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд 1,205.2 сая төгрөгийг зарцуулахаар баталсан байна.

¹ “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нь энэхүү журмын 2.1-д бүрдүүлсэн орлогын хэмжээнд үндэслэн тухайн жилийн төсвийн суурь зарлагын төлөвлөгөөнд дараах арга хэмжээг тусгаж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулна. Үүнд: 2.2.1. Байгалийн ургамлын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан арга хэмжээ; 2.2.2. аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллага, агнуурын бүс нутгийн менежментийг хариуцагч хуулийн этгээдтэй зөвшилцөн аймгийн болон агнуурын бүс нутгийн агнуурын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ; 2.2.3. усны сав газрын захиргаа, аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллагын саналыг үндэслэн “Ус” үндэсний хөтөлбөр, усны нөөцийн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ; 2.2.4. аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллага, ойн ангитай зөвшилцөн аймаг, сум, нөхөрлөлийн ойн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ; 2.2.5. тухайн тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаатай зөвшилцөн тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөө, орчны бүсийн менежментийн тусгагдсан газрын нөхөн сэргээлт, бэлчээрийн менежментийн арга хэмжээ тус тус багтана.

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд 506.0 сая төгрөгийг зарцуулж 41.9 хувийн гүйцэтгэлтэй байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 1

д/д	Зардал	ИТХ-аас баталсан	Зарцуулсан	Хэрэгжилт хувь
1	Ус, рашааны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх	535.4	140.7	26.2
2	Ойн нөөцийн хамгаалах, нөхөн сэргээх	345.4	205.9	59.6
3	Ан амьтны нөөц хамгаалах, нөхөн сэргээх	119.0	54.9	46.2
4	Байгаль орчны цэвэрлэгээ, нөлөөллийн чиглэлээр	205.4	104.5	50.8
	Нийт	1,205.2	506.0	41.9

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний хэрэгжилт 41.9 хувьтай байгаа нь аймгийн төсөвт тодотгол хийж 337.4 сая төгрөгийн 7 төсөл арга хэмжээ хасагдаж, 316.4 сая төгрөгийн 9 төсөл арга хэмжээг дараа он руу шилжүүлснээс шалтгаалсан байна.

Аймгийн ИТХ-аас байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зарцуулалтад хяналт тавьсан баримт тайлан байхгүй байна. Энэ нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1-д заасан “*нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ, төсөв баталж, биелэлтэд хяналт тавих*,” гэсэн заалттай нийцэхгүй байна. Иймд аймгийн ИТХ-д хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээнд баталсан төсвийн биелэлтэд хяналт тавьж ажиллах зөвлөмж өгөв.

1.3 Аймгийн Засаг дарга байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлаар санхүүжих төсөл арга хэмжээг бодитой төлөвлөөгүй байна.

Аймгийн Засаг дарга нь 2020 онд байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардлаар 35 төсөл арга хэмжээнд нийт 1,257.6 сая төгрөгийг зарцуулахаар ИТХ-д оруулж батлуулсан байна.

Төсвийн тодотголоор 337.4 сая төгрөгийн 7 төсөл арга хэмжээ хасагдаж, 316.4 сая төгрөгийн 9 төсөл арга хэмжээг 2021 он руу шилжүүлсэн байна.

Хасагдсан 337.4 сая төгрөгийн 7 төсөл арга хэмжээ нь судалгаа, шинжилгээгүй төлөвлөгдсөнөөс хэрэгжээгүй байна.

Аймгийн төсвийн орлого бүрдүүлэлтэд хүндрэл үүссэн тул төсөвт тодотгол хийсэн байна. Төсвийн тодотголоор байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлаар санхүүжих 9 төсөл арга хэмжээг 2021 онд шилжүүлсэн байна.

Иймд аймгийн Засаг даргад хууль заасны дагуу байгаль хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд зарцуулах хөрөнгийг бодитой төлөвлөж байх зөвлөмж өгөв.

БҮЛЭГ 2. БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ОРЛОГЫГ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ДАГУУ ТӨВЛӨРҮҮЛСЭН БАЙНА.

2.1 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг бодитой төлөвлөсөн байна.

Аймгийн 2020 оны төсөвт ус, рашаан, ой, ургамал, амьтны нөөц ашигласны төлбөрт 3,926.1 сая төгрөгийн татварын орлого бүрдүүлэхээр төлөвлөж, 4,247.7 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг Төсвийн тухай хуульд заасан жилийн төсвийн хязгаарт багтаан төсвийн төслийг боловсруулсан эсэхийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 2				
д/д	Орлогын төрөл	2020 он		Зөрүү
		Сангийн яамнаас хянан ирүүлсэн хязгаар	Аймгийн төлөвлөгөө /сая.төгрөг/	
1	Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого	3,200.0	3,884.7	684.7
2	Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого	36.0	27.6	-8.4
3	Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого	34.0	13.8	-20.2
		3,270.0	3,926.1	656.1

Дээрх хүснэгтээс харахад ойн нөөц ашигласны төлбөрийн орлого 8.4 сая төгрөгөөр, ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого 20.2 сая төгрөгөөр сангийн яамнаас хянасан жилийн төсвийн хязгаараас тус тус бага байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8. “жилийн төсвийн хязгаар” гэж төсвийн тусгай шаардлага, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэн төсвийн ерөнхийлөн захирагчийн тухайн жилийн төсөв боловсруулахад баримтлах орлогын доод хэмжээ, зарлагын дээд хэмжээг; 14 дүгээр зүйлийн 14.2. Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 14.2.1. жилийн төсвийн хязгаарт багтаан төсвийн төслийг боловсруулах; гэсэн заалттай нийцэхгүй байна. Аймгийн санхүү, төрийн сангийн хэлтэст жилийн төсвийн хязгаарыг мөрдөж ажиллах зөвлөмж өгөв.

2.2 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг төлөвлөгөө биелсэн байна.

Аймгийн төсөвт 2020 онд ус, рашааны нөөц ашигласны төлбөр 4,143.5 сая төгрөг, ойн нөөц ашигласны төлбөр 27.4 сая төгрөг, ан амьтны нөөц ашигласны төлбөр 76.8 сая төгрөг нийт 4,247.7 сая төгрөг төвлөрүүлжээ.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 3

Д/д	Орлогын төрөл	2020 он		Зөрүү
		Төлөвлөгөө /сая.төгрөг/	Гүйцэтгэл /сая. төгрөг/	
1	Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого	3,884.7	4,143.5	258.8
2	Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого	27.6	27.4	-0.2
3	Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого	13.8	76.8	63.0
		3,926.1	4,247.7	321.6


дээрх хүснэгтээс харахад байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого нийт дүнгээрээ 321.6 сая төгрөг буюу 8.2 хувиар давж биелсэн байна.

Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого 63.0 сая төгрөгөөр давж биелсэн нь БОАЖЯ-аас Дорнод аймагт ашиглах ан амьтны нөөцийн хэмжээг аймгаас төлөвлөснөөс хойш тогтоосноос шалтгаалжээ.

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6², 23.8³ -д заасны дагуу үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан ус, рашааны төлбөрийг аймгийн төсөвт, ан амьтан, байгалийн ургамал, ой, хүн амын унд ахуйн хэрэгцээний зориулалтаар ус, рашаан ашигласны төлбөрийг сумын төсөвт төвлөрүүлсэн байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг төрөл тус бүрээр нь графикаар харуулбал:

График 1



графикаас харахад байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын 97.0 хувийг ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого бүрдүүлжээ.

² 23.6.5.үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөр;

³ 23.8.4.агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж;

23.8.6.байгалийн ургамал ашигласны төлбөр;

23.8.7.ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр;

23.8.9.хүн амын унд, ахуйн хэрэгцээний зориулалтаар ус, рашаан ашигласны төлбөр;

БҮЛЭГ 3. БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ОРЛОГЫГ ХУУЛЬ, ЖУРАМД ЗААСАН АРГА ХЭМЖЭЭНД ЗАРЦУУЛААГҮЙ БАЙНА.

3.1 Ус ашигласны төлбөрийн орлогоос усны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээхэд хуульд заасан хувь, хэмжээнээс бага хөрөнгө төлөвлөсөн байна.

Аймгийн төсөвт 2019 онд ус, рашааны нөөц ашигласны төлбөр 3,988.3 сая төгрөг, ойн нөөц ашигласны төлбөр 53.1 сая төгрөг, ан амьтны нөөц ашигласны төлбөр 114.1 сая төгрөг нийт 4,155.5 сая төгрөг төвлөрүүлжээ.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд хувь, хэмжээгээр байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн эсэхийг үзэхэд:

Ус ашигласны төлбөрийн орлогоос усны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь, хэмжээний доод хязгаарыг мөрдөөгүй байна.

Байгаль хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд зарцуулах хөрөнгийг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Энэ хуулийн 13.2-т заасан төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь, хэмжээний доод хязгаарыг дараах байдлаар тогтооно: Үүнд 1. Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлогоос 15 хувь,..., 5. Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогоос 35 хувиар” гэж заасан.

Хүснэгт 4 /сая төгрөг/

д/д	Орлогын төрөл	2019 оны орлогын гүйцэтгэл	Хуульд заасан хувиар тооцоход	ИТХ-аас баталсан	Зөрүү
1	Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого	3,988.3	1,395.9	535.4	860.5

Ус ашигласны төлбөрийн орлогоос усны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд 2020 онд Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн дагуу 1,395.9 сая төгрөг төлөвлөх шаардлагатай ч аймгийн ИТХ-аар 535.4 сая төгрөг батлуулсан байна. Энэ нь Сангийн яамнаас усны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төсвийн хязгаарыг хуульд заасан хувь хэмжээгээр төлөвлөж ирүүлээгүйгээс шалтгаалсан байна.

3.2 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг хууль, журамд заасан арга хэмжээнд зарцуулаагүй байна.

Аймгийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх сангийн хөрөнгөөр 2020 онд 19 төсөл арга хэмжээнд нийт 506.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг хууль, тогтоомжид заасан арга хэмжээнд зарцуулсан эсэхийг шалгахад:

Агаарын бохирдлыг бууруулах дэд хөтөлбөрт 10.0 сая төгрөг, бэлчээрийн менежментийн сайжруулах, хадлан тэжээл, газар тариалангийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтэд хяналт тавих зардал 10.0 сая төгрөг, мотоцикл худалдан авахад 2.0 сая төгрөг, цэмцгэр Чойбалсан хөтөлбөрт 80.0 сая төгрөг нийт 4 төсөл арга хэмжээнд 102.0 сая төгрөгийг зарцуулсан нь Засгийн газрын 2014 оны 43 дугаар

тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-д заасантай нийцэхгүй байна. Иймд аймгийн Засаг дарга, аймгийн ЗДТГ-ын хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргад байгаль хамгаалах сангийн хөрөнгийг хууль, тогтоомжид заасны дагуу төлөвлөж, зарцуулж байх албан шаардлага өгөв.

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээг газар дээр очиж үзэхэд:

Нийтийн эзэмшлийн талбайн хөрсийг элэгдлээс хамгаалах зорилгоор ногоон байгууламжийн талбайг нэмэгдүүлэхэд 93.4 сая төгрөг, цэмцгэр Чойбалсан хөтөлбөрийн хүрээнд хогийг цэвэрлэхэд 80.0 сая төгрөг, бурхан багшийн цэцэрлэгт хүрээлэнгийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, тохижуулахад 90.0 сая төгрөг нийт 263.4 сая төгрөгийн 3 төсөл арга хэмжээ нь батлагдсан зураг, төсвийн дагуу хийгдээгүй байна. Энэ нь төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн “41.2.3.төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;” гэсэн заалттай нийцэхгүй байна. Иймд аймгийн Засаг дарга, аймгийн ЗДТГ-ын хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргад байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх төсөл арга хэмжээний гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах албан шаардлага өгөв.

Баян-Уул суманд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн “Хурандаа”, “Хуст”-ын булгийн эхийг хашсан 11.6 сая төгрөгийн ажлын бодит байдалтай газар дээр нь очиж үзэхэд хашаа нурсан, булгийн эх дотор мал орсон байдалтай байсан. Иймд сумын Засаг дарга, байгаль хамгаалагч нарт гүйцэтгэгч компаниар засварлуулж, хяналт тавьж ажиллах албан шаардлага өгөв.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:



МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

21000, Чойбалсан, Дорнод аймаг
Утас: 7058-4202, Факс: 7058-4584

2021. 10. 28 № 1/2142

танай _____ -ны № _____ -т

ДОРНОД АЙМАГ ДАХЬ АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.БОЛОРТУУЛ ТАНАА

Г Санал хүргүүлэх тухай 7

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газраас 2020 оны “Байгаль орчныг хамгаалах тухай хууль, тогтоомжийн хэрэгжилт”-д хийсэн нийцлийн аудитын тайлангийн төслийг хүлээн авч танилцлаа.

Тайлангийн төсөлд тусгагдсан дүгнэлтүүдтэй холбоотой дараах саналыг хүргүүлж байна.

1.Дүгнэлт 3-т өгөх санал: 2020 онд аймгийн нэгдсэн төсвийн орлого бүрдүүлэлтэд хүндрэл учирч төсвийн тодотгол хийсэн. Тодотголоор 9 арга хэмжээг 2021 онд шилжүүлсэн болно.

2.Дүгнэлт 5-д өгөх санал: Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос зарцуулах дээд хязгаарыг Сангийн яамнаас хянаж ирүүлдэг болно.

3.Зөвлөмжийн 3-т өгөх санал: Усны тооллого хийх төсөв, зардлыг 2018, 2019 онуудад батлаагүй тул тооллого хийгдээгүй бөгөөд энэ онд 9,0 сая төгрөгөөр усны тоо бүртгэлийн ажил хийгдэж дуусмагц үр дүнг мэдээллийн санд байршуулж зөвлөмжид заасан хугацаанд хүргүүлнэ.

4.Тайлангийн төслийн 3.2-т өгөх санал: Баян-Уул суманд 50 га талбайд ойжуулалт хийх ажлын гүйцэтгэл, тайланг нөхөн хүргүүлэв.

Дорнод аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас холбогдох материалыг хавсралтаар хүргүүлэв.

ЗАСАГ ДАРГА



М.БАДАМСҮРЭН

0105 1212

ИРҮҮЛСЭН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР:

1. Санал 1 дэх асуудлын дүгнэлтэд өөрчлөлт оруулж тайланд тусгалаа.
2. Санал 2 дахь асуудлын дүгнэлтэд өөрчлөлт оруулж тайланд тусгалаа.
3. Санал 4 дэх асуудлыг хүлээн авч тайланд өөрчлөлт орууллаа.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг төлөвлөхдөө хууль, журамд заасны дагуу менежментийн төлөвлөгөө, мэдээллийн санд үндэслэн боловсруулаагүй байна.
2. Аймгийн ИТХ нь байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээний биелэлтэд хяналт тавьж ажиллаагүй байна.
3. Аймгийн Засаг дарга байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлаар санхүүжих төсөл арга хэмжээг бодитой төлөвлөөгүй байна.
4. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө биелсэн байна.
5. Ус ашигласны төлбөрийн орлогоос усны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээхэд хуульд заасан хувь, хэмжээнээс бага хөрөнгө зарцуулсан байна.
6. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг хууль, журамд заасан арга хэмжээнд зарцуулаагүй байна.

Аудитаар нийт 714.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнд зөрчил арилгуулах 377.0 сая төгрөгийн 2 албан шаардлага, 337.4 сая төгрөгийн 4 зөвлөмж өгч ажиллалаа.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Аймгийн ИТХ-ын даргад:

1. Байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээний биелэлтэд хяналт тавьж ажиллах.
2. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг хууль, журамд нийцсэн байдлыг хянаж баталж байх.

Аймгийн Засаг дарга болон Байгаль орчин, аялал жуулчлалын газарт:

1. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг төлөвлөхдөө хууль, журамд заасны дагуу менежментийн төлөвлөгөө, мэдээллийн санд үндэслэн боловсруулж байх.
2. Усны тоо бүртгэлийг зохион байгуулж, мэдээллийн санд оруулж ажиллах.

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг 2022 оны 10 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ:



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2021 оны 11 сарын 03 өдөр

Дугаар 21

Чойбалсан хот

Г

Тайлан баталгаажуулах тухай

Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.2, 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх заалтыг тус тус үндэслэн **ТУШААХ нь:**

1. “Байгаль орчныг хамгаалах тухай хууль, тогтоомжийн хэрэгжилт”-д хийсэн нийцлийн аудитын тайланг баталсугай.
2. Аудитаар өгсөн албан шаардлагыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг Дорнод аймгийн ИТХ-ын дарга М.Энхтөр, аймгийн Засаг дарга М.Бадамсүрэн, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга А.Гантулга нарт хүргүүлсүгэй.
4. Нийцлийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор Б.Батжаргалд даалгасугай.



Б.БОЛОРТУУЛ

011010020

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудиторын 2021 оны
11 дүгээр сарын 03-ны өдрийн
21 дүгээр тушаалын хавсралт

№	Байгууллагын нэр	Албан шаардлагын дугаар	Албан шаардлагын утга	Албан шаардлагын дүн /сая.төг/
1	Дорнод аймгийн Засаг дарга	01/389 ДОА-2021/80-ШТА-НА	Зөрчил арилгах тухай	365.4
2	Баян-Уул сумын Засаг дарга	02/390 ДОА-2021/80-ШТА-НА	Зөрчил арилгах тухай	11.6

АЛБАН ШААРДЛАГА:



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 11 сарын 03 өдөр

Дугаар 01/382/200А-2021/80-ШТА-НА

Чойбалсан хот

Г

Зөрчил арилгах тухай

Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 10 дугаар зүйлд тодорхойлогдсон Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Байгаль орчныг хамгаалах тухай хууль, тогтоомжийн хэрэгжилт”-д хийсэн нийцлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Нийтийн эзэмшлийн талбайн хөрсийг элэгдлээс хамгаалах зорилгоор ногоон байгууламжийн талбайг нэмэгдүүлэхэд 93.4 сая төгрөг, цэмцгэр Чойбалсан хөтөлбөрийн хүрээнд хогийг цэвэрлэхэд 80.0 сая төгрөг, бурхан багшийн цэцэрлэгт хүрээлэнгийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, тохижуулахад 90.0 сая төгрөг нийт 263.4 сая төгрөгийн 3 төсөл арга хэмжээ нь батлагдсан зураг, төсвийн дагуу хийгдээгүй байна. Энэ нь төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн “41.2.3.төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;” гэсэн заалттай нийцэхгүй байна.

2. Агаарын бохирдлыг бууруулах дэд хөтөлбөрт 10.0 сая төгрөг, бэлчээрийн менежментийн сайжруулах, хадлан тэжээл, газар тариалангийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтэд хяналт тавих зардал 10.0 сая төгрөг, мотоцикл худалдан авахад 2.0 сая төгрөг, цэмцгэр Чойбалсан хөтөлбөрт 80.0 сая төгрөг нийт 4 төсөл арга хэмжээнд 102.0 сая төгрөгийг зарцуулсан нь Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-д заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давшан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.” Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.6, 4.2.1.11-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх сангийн хөрөнгийг хууль, журмын дагуу төлөвлөж зарцуулах, батлагдсан төсөл арга хэмжээний гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах,

011041296

2. Албан шаардлагын биелэлтийг 2022 оны 10 дугаар сарын 25-ны дотор ирүүлэхийг аймгийн Засаг дарга М.Бадамсүрэн, аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Алтансүх нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

Б.БАТЖАРГАЛ

М.УХААНБИЛЭГ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 11 сарын 03 өдөр

Дугаар 04/390-ДОР-2021/30-ШТА-НА

Чойбалсан хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 10 дугаар зүйлд тодорхойлогдсон Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Байгаль орчныг хамгаалах тухай хууль, тогтоомжийн хэрэгжилт”-д хийсэн нийцлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Баян-Уул суманд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн “Хурандаа”, “Хуст”-ын булгийн эхийг хашсан 11.6 сая төгрөгийн ажлын гүйцэтгэлтэй газар дээр нь очиж үзэхэд хашаа нурсан, эвдэрсэн, булгийн эх дотор мал, амьтад орох боломжтой болсон байсан. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 Захиалагч бараа, ажил, үйлчилгээг худалдан авах талаар даараах эрх, үүрэгтэй байна: 46.1.6 “бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавих” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.” Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.9, 4.2.1.11-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төсөл арга хэмжээний гэрээнд заасны дагуу гүйцэтгэгч компаниар засварлуулах,
2. Албан шаардлагын биелэлтийг 2022 оны 10 дугаар сарын 25-ны дотор ирүүлэхийг Баян-Уул сумын Засаг дарга Х.Баттулгад даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР

Б.БОЛОРТУУЛ

Б.БАТЖАРГАЛ

М.УХААНБИЛЭГ

011041300

ДОРНОД АЙМАГ, ХЭРЛЭН СУМ, 7-Р БАГ АЙМГИЙН ЗДТГ-ЫН 2 ДУГААР БАЙР
УТАС: +976 7058-4203, 7058-4204, 7058-4207
И-МЭЙЛ: DORNOD@AUDIT.GOV.MN , ВЕБ САЙТ: WWW.AUDIT.MN